

бүлийнхээ амьдралд оролцох, курс эмчилгээнд хамрагдах зайлшгүй шаардлага-хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэн тайлбарласныг шүүх “үндэслэлтэй” гэж хүлээн авбал түүнийг нэг хүртэл жилийн хугацаагаар хагас эрх чөлөөт нөхцөлд хорих ялаа эдлэх шийдвэр гаргадаг. Тодруулбал ялтан үлдсэн ялаа хорих байгууллагын дотор энэхүү хагас эрх чөлөөт нөхцөлд эдэлдэг.

**М.ЦЭНД**

Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Москвагийн их сургуулийн адъюнкт, хурандаа

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны түргэн шуурхай, шударга явагдах нөхцөлийг хангахад “хугацаа” хэмээх ойлголт чухал ач холбогдолтой. Байцаан шийтгэх ажиллагааг хурдан шуурхай, чанартай гүйцэтгэж, гэмт этгээдэд тохирох ял шийтгэл оноох хэрээр байцаан шийтгэх ажиллагааны зорилт амжилттай хэрэгжиж байдаг. Хугацаа нь ЭБША-г шуурхай явуулах, тухайн ажиллагааны явцад хүний эрхийг баталгаатай хангах, иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, иргэд хуулийг дээдлэн, хууль сахиулах байгууллагыг хүндэтгэх, ЭБША-ны зорилтыг хангаж, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх зэрэгт чухал үүрэгтэй

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны төрөл хэлбэрүүдийн зааг ялгааг харуулах хүчин зүйл болно.
2. Эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал, нотлох баримтуудыг цуглуулах боломж олгоно.
3. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч эрх бүхий субъектүүдийн хууль ёсны шийдвэрт чухал нөлөө үзүүлнэ.

Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид тодорхой төрлийн хязгаарлалтыг цаг хугацааны хувьд зааж өгсөн бөгөөд энэ нь төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны хууль ёсны шийдвэрээр хэрэгжинэ. Эрүүгийн хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн, шуурхай, шударга, бодитой шийдвэрлэхэд “байцаан шийтгэх ажиллагааны хугацаа”-ны тухай асуудал чухал байр суурь эзэлнэ. Хууль тогтоомжид “хугацаа”-г тодорхой зааж өгсөөр байтал түүнийг зөрчих нь хүний эрхийг ноцтой зөрчихөд ч хүргэж болзошгүй.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолд “хугацаа”-г хэд хэд ангилан үздэг. Байцаан шийтгэх ажиллагааны “хугацаа” гэдэг нь тодорхой төрлийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах эхлэл, төгсгөлийг хуульчлан тодорхойлж өгсөн хэмжээ юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлэх, сунгах, сэргээх, тухай Монгол Улсын ЭБШХуулийн 96 дугаар зүйл \хугацаа тоолох\, 97 дугаар зүйл \хугацаа сунгах\, 98 дугаар зүйл \хугацаа сэргээх\-д тус тус тодорхойлон зааж өгсөн байна. Байцаан шийтгэх ажиллагааны хугацааг уг ажиллагаанд оролцогч эрх бүхий этгээдүүд ягштал баримтлах үүрэгтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг нэн даруй хэрэгжүүлэх, тодорхойлон заасан гэж ангилж болно. Байцаан шийтгэх ажиллагааны онцлогоос шалтгаалан богино хугацаанд шуурхай гүйцэтгэхийг заан хуульчилж, тухайн үед нь шуурхай шийдвэрлэх агуулга бүхий “нэн даруй” “тэр даруй” хэмээн илэрхийлсэн болон тодорхой ажиллагааны эхлэл, төгсгөлөөр тодорхойлсон хугацаа юм. Жишээлбэл: гэмт

хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэхийн тулд ЭБШХ-н 172.3-р зүйлд заасан хошлуулшгүй ажиллагааг нэн даруй явуулж болно. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтэнд ямар хэрэгт сэжиглэгдэж байгаа тухай тэр даруй мэдэгдэх ба сэжигтэн яллагдагчийг цагдан хорих, эсвэл суллах захирамжийг батлагдмагц нь нэн даруй хэрэгжүүлнэ.

Тодорхойлон заасан хэм хэмжээний хувьд Монгол Улсын ЭБШХуулийн 178.1-р зүйл \ Хэрэг бүртгэлт явуулах хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 21 хоног байна\, 182-р зүйл \Мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар байна\ гэх мэт олон жишээг дурдаж болно. ЭБШХуулинд хугацааг цагаар, хоногоор, сараар, жилээр тоолохоор заасан байдаг

Эрүүгийн байцаан шийтгэх хугацааг дараах байдлаар 3 хуваан үзэх саналыг дэвшүүлж байна. Энэ нь:

1. Байцаан шийтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангахад чиглэсэн:

-Гэмт хэргийн тухай гомдол мэдээллийн шалган шийдвэрлэх хугацаа 5 хоног \ЭБШХуулийн 171-р зүйл\

2. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах баталгааг хангахад чиглэсэн:

-Сэжигтнийг баривчлах \ЭБШХ-н 59.5-р зүйл\

-Сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах \ЭБШХ-н 68.4, 69-р зүйлүүд\

-Хүсэлт, гомдол, мэдээллийг хянан үзэх \171.1.2, 104.5, 108.1,113.1, 114.2-р зүйлүүд\

3. Мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих прокурорын хяналтыг хангаж хууль ёсыг сахин биелүүлэхэд чиглэсэн:

-Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны хугацааг сунгах \ЭБШХ-н 178.3, 182.4-р зүйлүүд\

-Хойшлуулшгүй тохиолдолд нэн даруй гүйцэтгэсэн ажиллагааны тухай прокурорт 24 цагийн дотор мэдээлэх \ЭБШХуулийн 59.5, 133.2-р зүйлүүд\

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг эх сурвалжаар нь императив буюу диспозитив гэж хуваан үзэж болно. Императивный хугацаа гэдэг нь хуульд хатуу тодорхойлон заасан хугацааг хэлнэ. Энэ нэр томъёонд дараах шинж тэмдэг агуулагддаг.

-Хуулиас өөр хэн ч тогтоох эрхгүй

-Хэн ч өөрчлөх боломжгүй

-Сунгагддаггүй

Императивный хугацааг ЭБШХуулийн 60.2-т “Сэжигтнийг баривчилснаас хойш 72 цагийн хугацаа дуусч цагдан хорих тухай шүүгчийн шийдвэр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид мэдэгдэж цагдан хорих байрны дарга суллана”. 178.1-т “Хэрэг бүртгэлт явуулах үндсэн хугацаа 21 хоног байна” гэж тодорхойлжээ.

Диспозитив хугацаа гэдэг нь хуульд дээд хэмжээг тодорхойлж өгсөн хугацааг хэлнэ. Диспозитивный хугацааг

ЭБШХуулийн 35.4-т “Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч гэмт хэрэгт сэжиглэгдсэн тухай сэжигтний гэр бүлийн гишүүнд 48 цагийн дотор мэдэгдэнэ”, 59.5-д “Хойшлуулшгүй тохиолдолд сэжигтнийг шууд баривчилж тогтоолыг 24 цагийн дотор прокурорт болон шүүхэд хүргүүлнэ” гэж заасан байна.

Гэмт хэргийг шуурхай, халуун мөрөөр нь илрүүлэх явдал нь зөвхөн гэмт этгээдийг тогтоогоод зогсохгүй, нотлох баримтыг цаг алдалгүй илрүүлэх, гэмт хэргийг үнэн зөв шалган шийдвэрлэх, нийгэмд учирсан хор хохирлыг түргэн хугацаанд барагдуулах, дахин давтан гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

